



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор сумын 14-р цэцэрлэг 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2019/153/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

(Хотын нэр оруулах)

2019 он

Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 7044-2584

Аудитын менежер: Д.Цэцэгмаа

Утас: 7044-2424

Аудитор:

Утас: 99080969

Цахим хаяг: munkhbat@audit.gov.mn

Цахим хаяг: tsegsegmaad@audit.gov.mn

Ж.Чогсомжанлав

Цахим хаяг: Chogsom83@Gmail.com

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	4
2.1	Оршил.....	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал..... Error! Bookmark not defined.	
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	8
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11.	Шилэн дансны мэдээлэл	8
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
3	Менежментийн захидал Error! Bookmark not defined.	
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	9

1 Аудитын гэрчилгээ

Батлагдсан гэрчилгээ скайннердаж энд оруулах

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Баянхонгор сумын 14-р цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Цэцэрлэгийн эрхлэгч Д.Ичинноровд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор сумын 14-р цэцэрлэгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор сумын 14-р цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.02.08-наас 2019.02.09-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.02.25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын Гэрээт аудитор Ж.Чогсомжанлав хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор сумын 14-р цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2019.02.25-ны өдрийн 14/04 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Баянхонгор сумын 14-р цэцэрлэгийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Баянхонгор сумын 14-р цэцэрлэг нь Хүүхдийг өөрийнх нь хүссэнээр чөлөөтэй тоглуулж, хүүхдэд өөрсдөө хэлэх, ажиллах, шийдэх боломж олгосноор үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлдэг, өөртэй итгэлтэй, бэрхшээлийг даван туулах чадвартай болгон хөгжүүлнэ. гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Баянхонгор сумын 14-р цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Байгууллагын хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх үзэл баримтлалтай уялдуулан СӨБ-ын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх, сургалтын агуулга, арга зүйд ахиц гарган, хүүхэд нэг бүрийн хөгжлийг хангахад анхаарч ажиллах.
- СӨБ-ын орчны стандартыг мөрдөн хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд сурч хөгжих боломжийг нэмэгдүүлэх.
- Өдөр тутмын үйл ажиллагааг цагийн хуваарийн дагуу үр дүнтэй чанартай, зохион байгуулах.

- Хамт олноороо ёс зүйг эрхэмлэн, ажлын хариуцлагыг эрхэмлэх.
- Хүүхдийн хоол хүнсний хангамж, үйлчилгээ, эрүүл зохистой хэрэглээг хангаж ажиллана.
- Эцэг эх олон нийттэй хамтран ажиллана.
- Багш ажилчдын ажлын үр дүнг үнэлнэ.

Баянхонгор сумын 14-р цэцэрлэгийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Баянхонгор сумын 14-р цэцэрлэгийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Багш ажилчдын бүтээлч сэтгэлгээг хөхүүлэн дэмжиж, тэдний ажлын байрандаа тасралтгүй хөгжих боломжийг ханган, багш ажилтныг багаар ажиллуулан чадваржуулж, сургалтын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд цэцэрлэгийн удирдлага, арга зүйч, багш ажилтан нар хамтран СӨБ-ын сургалтын орчны стандартын бүрдүүлэн, хүүхдэд ээлтэй цэцэрлэг болох зорилго тавин ажиллаж байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Баянхонгор сумын 14-р цэцэрлэгийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд 50 оноо авсан тул мэдээлэл технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Баянхонгор сумын 14-р цэцэрлэгийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acolous” программ хангамж ашигладаг байна.

Баянхонгор сумын 14-р цэцэрлэг дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Баянхонгор сумын 14-р цэцэрлэгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 8 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 8 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд Баянхонгор сумын 14-р цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайланд аудит хийж санал дүгнэлт гаргахад шаардлагатай материаллаг байдлын түвшинг урьдчилсан байдлаар тооцохдоо суурь үзүүлэлтийг үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгох нь зохимжтой гэж үзэв.

Гүйцэтгэлийн шатанд шинж чанарын болон орчин нөхцөлийн хувьд материаллаг байдал илрээгүй болно. Баянхонгор сумын 14-р цэцэрлэгийн 2018 оны нийт зардал 159.2 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 3.2 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, Маягт № Б201-ээр баримтжуулан баталгаажуулав.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх

үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 8 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 1 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 7 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Байхгүй

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Баянхонгор сумын 14-р цэцэрлэгийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 147211.0 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 3.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 145150.9 мянган төгрөг буюу 98.6 хувьтай байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Баянхонгор сумын 14-р цэцэрлэгийн шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллага нь Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас хийсэн “ Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд хийсэн аудит”-таар Шилэн дансны хуулийн 6.1-д заасан мэдээллийн өөрт хамаарах 25 мэдээллийг хугацаанд нь ,6.4-д заасан мэдээллээс

өөрт хамаарах 5,0 сая төгрөгөөс үнийн дүн бүхий орлогын 6 гүйлгээ байгааг хугацаанд тус тус мэдээлж хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Зөвлөмж өгөөгүй.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баянхонгор сумын 14-р цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Баянхонгор сумын 14-р цэцэрлэгийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

3 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>12,555,817.00</u>	<u>12,971,050.52</u>
33	АВЛАГА	4,800,000.00	30,901.00
335	Бусад авлага	4,800,000.00	30,901.00
3351	Байгууллагаас авах авлага	4,800,000.00	30,901.00
35	БАРАА МАТЕРИАЛ	7,755,817.00	12,940,149.52
351	Түүхий эд материал	00.00	1,578,576.00
35110	Тусгай зориулалттай материал	00.00	1,558,776.00
35130	Эм боох материал	00.00	19,800.00
354	Хангамжийн материал	7,755,817.00	11,361,573.52
35410	Бичиг хэргийн материал	00.00	144,250.00
35420	Аж ахуйн материал	7,024,267.00	8,484,417.00
35450	Барилгын засварын материал	00.00	1,302,700.00
35460	Хүнсний материал	731,550.00	1,177,606.52
35470	Бусад хангамжийн материал	00.00	252,600.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>21,103,394.05</u>	<u>361,947,464.48</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	21,103,394.05	361,947,464.48
392	Биет хөрөнгө	20,267,394.06	361,089,464.53

Баянхонгор сумын 14-р цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

39201	Барилга, байгууламж, орон сууц	00.00	333,327,366.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-535,076.32
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	7,266,670.00	22,624,870.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-393,393.32	-4,901,624.97
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	14,016,034.00	14,016,034.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-621,916.62	-3,442,104.18
393	Биет бус хөрөнгө	835,999.99	857,999.95
39301	Програм хангамж	880,000.00	1,078,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-44,000.01	-220,000.05
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	33,659,211.05	374,918,515.00
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	75,990.00	00.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	75,990.00	00.00
413	Өглөг	75,990.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	33,583,221.05	374,918,515.00
51	Засгийн газрын хувь оролцоо	33,583,221.05	374,918,515.00
512	Хуримтлагдсан үр дүн	33,583,221.05	182,651,961.63
51210	Өмнөх үеийн үр дүн	33,583,221.05	33,583,221.05
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	149,068,740.58
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	00.00	192,266,553.37
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	33,659,211.05	374,918,515.00

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	71,505,304.00	308,237,250.09
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	161,026,241.09
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	161,026,241.09
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	161,026,241.09
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	161,026,241.09
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	71,505,304.00	1,239,909.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	54,104,600.00	00.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	54,104,600.00	00.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	00.00	145,971,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	1,239,909.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	1,239,909.00
1330	Төсвийн захирагчдаас	17,400,704.00	00.00
133003	Хөрөнгийн	17,400,704.00	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	37,922,082.95	159,168,509.51
21	УРСГАЛ ЗАРДАЛ	37,922,082.95	159,168,509.51
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	33,980,080.79	157,991,828.51
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	18,692,858.00	95,019,137.00
210101	Үндсэн цалин	18,692,858.00	94,303,080.00
210102	Нэмэгдэл	00.00	513,057.00
210104	Урамшуулал	00.00	203,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,056,214.84	11,403,107.00
210201	Тэтгэврийн даатгал	2,056,214.84	9,303,756.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	2,099,351.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,253,219.00	11,075,310.00
210301	Гэрэл, цахилгаан	277,019.00	2,054,570.00
210302	Түлш, халаалт	1,330,500.00	3,785,760.00
210303	Цэвэр, бохир ус	1,645,700.00	5,234,980.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,938,945.00	2,631,500.00

Баянхонгор сумын 14-р цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210401	Бичиг хэрэг	207,700.00	63,000.00
210402	Тээвэр, шатахуун	800,000.00	1,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	252,107.00	801,980.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	205,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	679,138.00	561,520.00
2105	Нормативт зардал	6,280,187.00	19,620,226.48
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	6,675.00
210502	Хоол, хүнс	6,280,187.00	19,613,551.48
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	392,849.00	6,600,200.00
210604	Урсгал засвар	392,849.00	6,600,200.00
2107	Томилолт, зочны зардал	00.00	53,000.00
210702	Дотоод албан томилолт	00.00	53,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	147,498.00	285,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	147,498.00	285,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,218,309.95	11,303,748.03
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	159,000.00	215,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,059,309.95	11,087,948.03
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,942,002.16	1,176,681.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,900,000.00	356,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,900,000.00	356,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	42,002.16	820,181.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	42,002.16	820,181.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	33,583,221.05	149,068,740.58
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	33,583,221.05	149,068,740.58

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	00.00	147,211,009.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	00.00	147,211,009.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	00.00	145,971,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	1,239,909.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	1,239,909.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	00.00	147,211,009.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	00.00	147,211,009.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	00.00	146,034,328.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	00.00	95,243,707.00
210101	Үндсэн цалин	00.00	90,655,134.00
210102	Нэмэгдэл	00.00	2,420,812.00
210104	Урамшуулал	00.00	2,167,761.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	00.00	11,285,428.00
210201	Тэтгэврийн даатгал	00.00	8,968,039.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	507,813.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	720,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	180,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	909,176.00

Баянхонгор сумын 14-р цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	00.00	11,075,310.00
210301	Гэрэл, цахилгаан	00.00	2,054,570.00
210302	Түлш, халаалт	00.00	3,785,760.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	5,234,980.00
2104	Хангамж, бараа материалын зардал	00.00	2,462,900.00
210401	Бичиг хэрэг	00.00	63,000.00
210402	Тээвэр, шатахуун	00.00	1,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	00.00	801,980.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	597,920.00
2105	Нормативт зардал	00.00	20,338,683.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	26,475.00
210502	Хоол, хүнс	00.00	20,059,608.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	252,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	3,585,600.00
210604	Урсгал засвар	00.00	3,585,600.00
2107	Томилолт, зочны зардал	00.00	53,000.00
210702	Дотоод албан томилолт	00.00	53,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	00.00	1,537,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	1,537,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	451,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	451,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	00.00	1,176,681.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	356,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	356,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	820,181.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	820,181.00

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	33,583,221.05	00.00	33,583,221.05
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	33,583,221.05	00.00	33,583,221.05
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	192,266,553.37	00.00	00.00	192,266,553.37
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	149,068,740.58	00.00	149,068,740.58
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	192,266,553.37	182,651,961.63	00.00	374,918,515.00

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны	Тайлант оны
-----------------------	----------	-----------	-------------

Баянхонгор сумын 14-р цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	54,104,600.00	54,062,597.84	147,211,009.00	144,330,738.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	54,104,600.00	54,062,597.84	147,211,009.00	144,330,738.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	50,204,600.00	50,162,597.84	146,854,509.00	143,974,238.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	18,700,300.00	18,692,860.00	95,627,509.00	93,911,745.00
210101	Үндсэн цалин	00.00	00.00	85,237,809.00	89,632,348.00
210102	Нэмэгдэл	00.00	00.00	3,784,100.00	2,111,636.00
210104	Урамшуулал	00.00	00.00	6,605,600.00	2,167,761.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,983,400.00	841,980,222.00	11,023,600.00	11,285,428.00
210201	Тэтгэврийн даатгал	00.00	00.00	7,188,500.00	8,968,039.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	00.00	958,800.00	507,813.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	00.00	767,000.00	720,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	00.00	191,800.00	180,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	00.00	1,917,500.00	909,176.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,276,300.00	3,253,219.00	11,320,400.00	10,830,220.00
210301	Гэрэл, цахилгаан	300,000.00	277,019.00	2,299,660.00	2,054,570.00
210302	Түлш, халаалт	1,330,600.00	1,330,500.00	3,785,760.00	3,540,670.00
210303	Цэвэр, бохир ус	1,645,700.00	1,645,700.00	5,234,980.00	5,234,980.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,020,100.00	3,018,059.00	2,798,400.00	2,462,900.00
210401	Бичиг хэрэг	100,000.00	194,200.00	51,100.00	63,000.00
210402	Тээвэр, шатахуун	800,000.00	800,000.00	1,000,000.00	1,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	252,400.00	252,107.00	1,130,400.00	801,980.00
210404	Ном, хэвлэл	00.00	00.00	28,200.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,867,700.00	1,771,752.00	588,700.00	597,920.00
2105	Нормативт зардал	12,458,000.00	12,457,287.00	20,456,300.00	20,221,591.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	00.00	26,400.00	26,475.00
210502	Хоол, хүнс	7,024,000.00	7,023,287.00	20,176,700.00	19,942,516.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,434,000.00	5,434,000.00	253,200.00	252,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,152,000.00	9,146,950.00	3,585,600.00	3,585,600.00
210602	Тавилга	4,102,000.00	4,102,000.00	00.00	00.00
210604	Урсгал засвар	5,050,000.00	5,044,950.00	3,585,600.00	3,585,600.00
2107	Томилолт, зочны зардал	00.00	00.00	53,000.00	53,000.00
210702	Дотоод албан томилолт	00.00	00.00	53,000.00	53,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,020,000.00	1,019,500.00	1,537,900.00	1,171,954.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,020,000.00	1,019,500.00	1,537,900.00	1,171,954.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	594500.00	594599.00	451800.00	451800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	594,500.00	594,500.00	451,800.00	451,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3900000.00	3900000.00	356500.00	356500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,900,000.00	3,900,000.00	356,500.00	356,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,900,000.00	3,900,000.00	356,500.00	356,500.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	54,104,600.00	54,062,597.84	147,211,009.00	145,150,919.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	54,104,600.00	54,062,597.84	147,211,009.00	145,150,919.00

Баянхонгор сумын 14-р цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	54,104,600.00	54,062,597.84	147,211,009.00	145,150,919.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	13.00	13.00	13.00	14.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	07.00	07.00	07.00	07.00
620003	Үйлчлэх ажилтан	05.00	05.00	05.00	06.00
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	00.00	00.00	65.00	65.00